



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/208

Ховд

┌ Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 104 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэг /улаан түвшин/-т шилжсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цагаас эхлэн 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.

2.Захирамжийг хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Сумдын Засаг дарга, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ